



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2011 оны 11сарын 23өдөр

Дугаар 331

Улаанбаатар хот

**“Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох
итгэлцүүр хэрэглэх журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Жолоочийн даатгалын тухай хуулийн 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газарт тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТООЦОХ ИТГЭЛЦҮҮР ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

НЭГ.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Жолоочийн даатгалын тухай хуулийн дагуу даатгуулагчийн төлөх хураамжийн хэмжээг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэхүү журам нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос гаргасан даатгалын багц дүрмийн хүрээнд мөрдөгдөнө.

ХОЁР.Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцоход ашиглах итгэлцүүр

2.1.Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцохдоо Жолоочийн даатгалын тухай хуулийн 11.1 дэх хэсэгт заасан итгэлцүүрийг хэрэглэнэ.

2.2.Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршлаас хамаарах итгэлцүүр (И₁)

2.2.1. И₁ нь дараах хэмжээтэй байна:

| Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршил | И ₁ |
|---|----------------|
| Улаанбаатар хот | 1.2 |
| Дархан-Уул, Орхон,Сэлэнгэ, Төв аймаг | 1.1 |
| Бусад аймаг, хот | 1.0 |

/ Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны 303 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.2.2.Тээврийн хэрэгслийг ашиглах газар нутгийн байршлыг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд бичигдсэн газар нутгийн байршлыг үндэслэнэ.

2.3.Өмнөх гэрээний хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын тоо, олгосон нөхөн төлбөрийн хэмжээнээс хамаарах итгэлцүүр (И₂)

2.3.1.И₂ нь дараах хэмжээтэй байна:

| Даатгалын гэрээ эхлэх үеийн бүлэг | И ₂ | Өмнөх 1 жилийн хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн даатгалын тохиолдлын үед нөхөн төлбөр олгосон тоо, эсхүл тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн буруугаас үүссэн зам тээврийн ослын улмаас жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тооноос хамаарах бүлэг | | | | |
|-----------------------------------|----------------|--|----------------|----------------|----------------|----------------|
| | | 0 удаа олгосон | 1 удаа олгосон | 2 удаа олгосон | 3 удаа олгосон | 4 удаа олгосон |
| М | 2.45 | 0 | М | М | М | М |
| 0 | 2.30 | 1 | М | М | М | М |

| | | | | | | |
|----|------|----|---|---|---|---|
| 1 | 1.55 | 2 | М | М | М | М |
| 2 | 1.40 | 3 | 1 | М | М | М |
| 3 | 1.00 | 4 | 1 | М | М | М |
| 4 | 0.95 | 5 | 2 | 1 | М | М |
| 5 | 0.90 | 6 | 3 | 1 | М | М |
| 6 | 0.85 | 7 | 4 | 2 | М | М |
| 7 | 0.80 | 8 | 4 | 2 | М | М |
| 8 | 0.75 | 9 | 5 | 2 | М | М |
| 9 | 0.70 | 10 | 5 | 2 | 1 | М |
| 10 | 0.65 | 11 | 6 | 3 | 1 | М |
| 11 | 0.60 | 12 | 6 | 3 | 1 | М |
| 12 | 0.55 | 13 | 6 | 3 | 1 | М |
| 13 | 0.50 | 13 | 7 | 3 | 1 | М |

/ Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны 303 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.3.2.И₂ итгэлцүүрийг жолоочийн даатгалын гэрээ байгуулах буюу гэрээг сунгах тухай бүрт заавал хэрэглэнэ.

2.3.3.Жолоочийн даатгалын гэрээ байгуулахад өмнөх 1 жилийн хугацаанд даатгуулагчийн буруугаас үүссэн тохиолдлын үед нөхөн төлбөр олгосон тоо, эсхүл тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн буруугаас үүссэн зам тээврийн ослын улмаас жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгосон тоог харгалзан даатгуулагчийн бүлгийг тогтооно.

/ Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны 303 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.3.4.Даатгалын тохиолдлыг бүртгэхдээ тухайн үед тээврийн хэрэгслийг жолоодож явсан жолоочийн түүх дээр бүртгэнэ.

2.3.5.Жолоочийн даатгалын гэрээг анх удаа байгуулж байгаа болон тухайн тээврийн хэрэгслийг жолоодох жолоочийн тоог хязгаарлахгүй тохиолдолд даатгуулагчийг 3 дугаар бүлэгт оруулж И₂=1 итгэлцүүрийг хэрэглэнэ.

2.3.6.Нэг даатгалын тохиолдолд олгосон нөхөн төлбөрийг нэг нөхөн төлбөр гэж тооцно.

2.3.7.Даатгалын гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө даатгалын гэрээг цуцалсны дараагаар шинээр гэрээ байгуулах үед даатгуулагчийн бүлгийг тогтоохдоо өмнөх гэрээний хугацаанд нөхөн төлбөр олгоогүй бол тэр үеийн бүлгийг авна. Хэрэв хугацаанаас нь өмнө цуцалсан гэрээ хүчин төгөлдөр байхад нөхөн төлбөр олгож байсан бол нөхөн төлбөрийн тоог харгалзан даатгуулагчийн бүлгийг тогтооно.

2.4.Даатгуулагчийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлагаас хамаарах итгэлцүүр (И₃)

2.4.1.И₃ нь дараах хэмжээтэй байна:

| | |
|---|----------------|
| Даатгалын баталгаанд дурдсан жолоочийн нас, автотээврийн хэрэгсэл жолоодох туршлага | И ₃ |
|---|----------------|

| | |
|--|------|
| 25 хүртэлх насны, 3 жил хүртэлх туршлагатай | 1.2 |
| 25 хүртэлх насны, 3 жилээс дээш туршлагатай | 1.15 |
| 25-оос дээш насны, 3 жил хүртэлх туршлагатай | 1.1 |
| 25-оос дээш насны, 3 жилээс дээш туршлагатай | 1.0 |

/ Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны 303 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.4.2. Даатгалын гэрээнд тээврийн хэрэгслийн жолоочийн нэр дурдахгүй буюу жолоочийн тоог хязгаарлаагүй тохиолдолд $I_3=1.2$ итгэлцүүрийг хэрэглэнэ.

2.4.3. Автотээврийн хэрэгслийг хэд хэдэн жолооч ашиглах бол тэдгээрийн хамгийн өндөр итгэлцүүрийг I_3 гэж тооцно.

2.5. Даатгалын гэрээний хугацаанаас хамаарах итгэлцүүр I_4

2.5.1. Даатгалын гэрээний хугацаа /1 жил/-наас хамаарах итгэлцүүр $I_4=1$ хэмжээтэй байна. */Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 173 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./*

2.5.2. Гадаад улсад бүртгэлтэй буюу Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа, дамжин өнгөрөх болон түр хугацаагаар ашиглах тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалд хамаарах итгэлцүүрийн хэмжээ, хураамжийг Жолоочийн даатгалын тухай хуулийн 26.4-д заасан журмын дагуу тогтооно.

2.6. Даатгуулагч даатгалын хураамжийн хэмжээг журамд зааснаас доогуур тогтоосон, эсхүл даатгалын нөхөн төлбөрийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхүйц худал мэдүүлэг санаатай өгсөн нь тогтоогдвол тус даатгалын гэрээ дууссаны дараа байгуулсан гэрээний даатгалын хураамжийг $I_5=1.3$ итгэлцүүрээр нэмэгдүүлж тооцно.

2.7. Тээврийн хэрэгслийг ашиглах жолоочийн тооноос хамаарах итгэлцүүр (I_6)

2.7.1. I_6 нь дараах хэмжээтэй байна:

| | |
|--|-------|
| Тээврийн хэрэгсэл ашиглах жолоочийн тоо | I_6 |
| Гэрээнд жолоочийн тоог зааж, нэр дурдсан | 1.0 |
| Гэрээнд жолоочийн тоог хязгаарлаагүй | 1.5 |

2.8. Тээврийн хэрэгслийн даац, зорчигчийн суудлын тоо, хөдөлгүүрийн хүчин чадлаас хамаарах итгэлцүүр (I_7)

2.8.1. I_7 нь дараах хэмжээтэй байна:

| | | |
|---|-------------------------------------|-------|
| Тээврийн хэрэгслийн ангилал, зориулалтын төрөл | | I_7 |
| <u>В ангилал</u> Хөдөлгүүрийн багтаамж /см ³ / | -1000 хүртэл | 0.9 |
| | -1001-2000 | 1.0 |
| | -2001-3000 | 1.1 |
| | -3001-4000 | 1.2 |
| | -4001-с дээш | 1.3 |
| <u>С ангилал</u> Тээврийн хэрэгслийн даац | -8 тонн хүртэлх даацтай | 1.0 |
| | -8болон түүнээс дээш тоннын даацтай | 1.3 |
| <u>Д ангилал</u> | -16 хүртэлх зорчигчийн суудалтай | 1.0 |

| | | |
|-------------|---|-----|
| Суудлын тоо | -16 болон түүнээс дээш зорчигчийн суудалтай | 1.3 |
|-------------|---|-----|

/ Энэ заалтад Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 07 дугаар сарын 03-ны 303 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулсан/

2.8.2.И₇ итгэлцүүрийг тогтоохдоо В, С болон D ангиллын тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалд энэхүү журмын 2.8.1-д заасан хүснэгтийг үндэслэнэ.

2.8.3.А болон “механизм” ангиллын тээврийн хэрэгслийн хувьд И₇=1 байхаар тооцно.

2.9.Тээврийн хэрэгслийн зориулалтаас хамаарах итгэлцүүр (И₈)

2.9.1.И₈ нь дараах хэмжээтэй байна:

| | |
|------------------------------------|----------------|
| Тээврийн хэрэгсэл өмчлөгчийн төрөл | И ₈ |
| Хувийн | 1.0 |
| Хуулийн этгээдийн | 1.5 |

2.9.2.Тээврийн хэрэгслийн зориулалтыг тогтоохдоо тээврийн хэрэгслийн гэрчилгээнд дурдсан өмчлөгчийн мэдээллийг үндэслэнэ.

2.10.Чиргүүлтэй эсэхээс хамаарах итгэлцүүр (И₉)

2.10.1.И₉ нь дараах хэмжээтэй байна:

| | |
|-----------------|----------------|
| Чиргүүлтэй эсэх | И ₉ |
| Чиргүүлгүй | 1.0 |
| Чиргүүлтэй | 1.2 |

ГУРАВ.Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тогтоох

3.1.Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тогтоохдоо дараах хүснэгтийг ашиглана:

| | Даатгалын хураамжийн төрөл | Даатгалын хураамжийг тооцох томьёо |
|---|---|--|
| 1 | Мэргэшсэн болон С, D ангиллын жолоочийн даатгалын хураамж | $X = X_0 \times I_2 \times I_3 \times I_4 \times I_5$ |
| 2 | Хувь хүний нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн даатгалын хураамж | $X = X_0 \times I_1 \times I_2 \times I_3 \times I_4 \times I_5 \times I_6 \times I_7 \times I_8 \times I_9$ |
| 3 | Хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн даатгалын хураамж | $X = X_0 \times I_1 \times I_4 \times I_5 \times I_6 \times I_7 \times I_8 \times I_9$ |

3.2.Энэхүү журмын 3.1-д заасан X₀-д Жолоочийн даатгалын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан даатгалын суурь хураамжийг ойлгоно.

3.3.Энэхүү журмын 3.1-д заасан И₁, И₂, И₃, И₄, И₅, И₆, И₇, И₈, И₉-д энэ журмын 2.2-2.10-д заасан итгэлцүүрийг ойлгоно.

ДӨРӨВ.Хяналт, хариуцлага

4.1.Хороо энэхүү журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--